

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОЮУТАН,
СУРАЛЦАГЧИД “ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ” ОЛГОХ,
ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, сангийн сайдын хамтарсан тушаал “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элссэн, үндсэн ангийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томьёо нь “Оюутны хөгжлийн зээл”-ийн журамд заасан нэр томьёотой ижил утга агуулна.

1.3. Гэрээний хавсралт дахь зээлийн эргэн төлөлтийн хуваарь нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Гэрээнд оролцогч талууд

2.1. Нэг талаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Боловсролын зээлийн сан (цаашид “Сан” гэх), Улаанбаатар хот-14191, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Энхтайваны өргөн чөлөө-10, Багшийн хөгжлийн ордон, түүнийг төлөөлж захирал (цаашид “Зээлдүүлэгч” гэх), нөгөө талаас сургуульд мэргэжлээр бакалавр \магистр, доктор\ын зэргийн боловсрол эзэмшихээр суралцаж буй аймаг \хөт\ын сум \дүүрэг\, баг \хороо\, гудамж/хороолол/-ын байрны тоотод оршин суугч овогтой /РД: / (цаашид “Зээлдэгч” гэх) нар нь (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн дагуу дараах нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү зээлийн гэрээг (цаашид “ГЭРЭЭ” гэх) байгуулав.

Гурав. Зээлийн нөхцөл

3.1. Зээлдэгч нь зээлийн хүсэлтээ сургуулиараа дамжуулж Санд гаргах бөгөөд нэмэлт зээлийн хүсэлтийг тухай бүрт нь “Оюутны хөгжлийн зээл”-ийн журмын шаардлага бүрэн хангаж байгаа эсэхийг хянан дараах нөхцөлөөр тухайн сургуулийн сургалтын төлбөрийн харилцах дансанд төгрөгөөр тооцож, бэлэн бусаар шилжүүлнэ.

3.2. “Оюутны хөгжлийн зээл”-ийг сургуулийн сургалтын төлбөрийн харилцах дансанд шилжүүлснээр талууд гэрээ байгуулагдсанд тооцох бөгөөд зээлдэгч нь сургуулийн дансанд шилжүүлэхийг хулээн зөвшөөрсөн болно.

3.3. сургуульд, **бакалаврын түвшинд** (мэргэжил) хөтөлбөрөөр 2.8 болон түүнээс дээш голч дүнтэй жилийн хугацаагаар суралцаж төгсөхөөр тохиром.

3.4. Зээл нь хүүгүй байна.

3.5. Зээл олгох хугацаа: Тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

3.6. Зээлдэгч энэ гэрээний 5.1.4-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд өмнөх зээлийн төлбөрийг “Оюутны хөгжлийн зээл”-ийн журамд заасан хугацаанд эргэн төлж болно.

3.7. Зээлдүүлэгч нь зээлдэгчийн авсан нийт санхүүжилтээс хамаарч “зээлийн эргэн төлөлтийн хуваарь”/Хавсралт №1/-ийн хугацааг тогтооно. Зээлдэгч нь зээлийн эргэн төлөх хуваарь байгуулсан өдрөөс эхлэн сар бүр энэхүү гэрээний 3.8-д заасан зээлийн дүнг Төрийн сан дахь **“Боловсролын зээлийн сан-ОХЗ”**-гийн **100900015271** тоот дансанд төгрөгөөр шилжүүлнэ.

3.8. Олгосон зээлийн хэмжээ:

№	Хичээлийн жил (улирал)	Зээлийн хэмжээ	Суралцагчийн гарын үсэг	Сургуулийн тэмдэглэл	Боловсролын зээлийн сангийн тэмдэглэл	Тайлбар
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
Дүн						

3.9. Талууд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сургууль төгсөхөөс 1 /нэг/ сарын өмнө баталгаажуулна.

Дөрөв. Зээлийг эргэн төлөх нөхцөл

4.1. Зээлийг сургууль төгссөн өдрөөс эхлэн 6 /зургаан/ жил хүртэлх хугацаанд буюу батлагдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.

4.2. Зээлдэгч эзэмшсэн мэргэжлээрээ орон нутагт төрийн албанад ажиллаж байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөх хугацааг 2 хүртэлх жилийн хугацаатай сунгахаар хүсэлт гаргаж болно.

4.3. Зээлдэгч зээлийн төлбөрийг зээл олголт, эргэн төлөлтийн хуваарыт заасан хугацаанаас нь өмнө төлөх эрхтэй. Зээлийг хэсэгчлэн төлөх тохиолдолд Сангаас зээлийн эргэн төлөлтийн хуваарыт өөрчлөлт оруулна.

4.4. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас захиргааны чөлөө авсан суралцагчийн хувьд өмнө олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу баталгаажуулан төлнө.

Тав. Талуудын эрх, үүрэг

5.1. Зээлдэгч нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.1.1. Зээлдэгч хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй багц цагийн хичээл судалж, бакалаврын хөтөлбөрт суралцагч бол 2.8, магистр болон докторын хөтөлбөрт суралцагч бол 3.2 голч дүнтэй дүгнүүлсэн байх;

5.1.2. Зээлдүүлэгчээс зээлийг хугацаанаас нь өмнө буцаан төлөхийг шаардсан мэдээллийг зээлдэгч хүлээн авмагц заасан хугацаанд зээлийн төлбөрийг нэн даруй төлөх;

5.1.3. Зээлдэгч нь сурлагын явц, хөдөлмөр эрхлэлт, байнгын болон түр оршин суух хаяг, холбоо барих утас, ажлын байр солигдох болон бусад мэдээллийг Сургууль, Санд үнэн зөв гаргаж өгөх, өөрчлөлт орсон тохиолдолд нэн даруй санд мэдэгдэх;

5.1.4. Зээлдэгч нь сонгосон (мэргэжил) сургалтын хөтөлбөрийн дагуу, курс давхардахгүй сургууль хооронд шилжсэн тохиолдолд зээл авах;

5.1.5. Зээлдэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэгүй, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлээ төлөөгүй тохиолдолд Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоол, Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлийн эргэн төлөлтийг графикт нийцүүлэх хүртэл хугацаанд зээлийг чанарын ангилалд шилжүүлэн бүртгэхийг зөвшөөрөх.

5.2. Зээлдүүлэгч нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.2.1. Гэрээний дагуу зээлдэгчийн сургалтын төлбөрийг тухайн сургуулийн сургалтын төлбөрийн харилцах төгрөгийн дансанд бэлэн бусаар шилжүүлэх;

5.2.2. Зээлдэгчийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх;

5.2.3. Зээлдэгчийн зээлийн гэрээг цуцлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох, зээлийн төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх;

5.2.4. Зээлдэгч хангалтгүй үнэлгээ авсан хичээлээ давтан суралцсан тохиолдолд тухайн хичээлд зориулан дахин зээл олгохгүй байх;

5.2.5. Зээлдэгчийн зээл олголт, эргэн төлөлтийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж ажиллах ба зээлдэгчид зээлийн талаарх үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх.

Зургаа. Гэрээ дуусгавар болох, цуцлах

6.1. Дараах тохиолдолд Сангийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, зээлийг бүрэн төлүүлнэ. Үүнд:

6.1.1. “Зээлийн эргэн төлөлтийн хуваарь”-ийг 2 /хоёр/ болон түүнээс дээш удаа зөрчих;

6.1.2. Зээлдэгч худал мэдээлэл өгсөн, хуурамч баримт бүрдүүлж зээл авах;

6.1.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургуулиас гарах, хасагдах;

6.1.4. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сургуулиас чөлөө авсан хэдий ч сургуулиас гарсан тохиолдолд гэрээний 6.1.3 дахь заалттай адилтган үзэх;

6.1.5. Зээлдэгч суралцах хугацаандаа мэргэжлээ сольж өөр мэргэжлээр дахин суралцаж эхлэх;

6.1.6. Гадаад оронд урт хугацаагаар зорчих / суралцах, ажиллаж амьдрах/.

6.2. Сан нь гэрээний 6.1-д заасны дагуу гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд гэрээг цуцлаагүй нь энэхүү эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.

6.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

6.4. Зээлдэгч нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас суралцах боломжгүй болсон тохиолдолд зээлийн гэрээг дуусгавар болгох бөгөөд зээлийн төлбөрөөс Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр бүрэн чөлөөлнө.

Долоо. Хариуцлага

7.1. Талууд энэ гэрээ болон хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд зээлдэгчийн зөвшөөрөлгүйгээр зээлийн талаарх нууцыг задруулахгүй.

7.2 Зээлдэгч зээлийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй аливаа шалтгаан (байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшиг, эрх бүхий этгээдээс тогтоосон хорио цээрийн дэглэм гм.) нь энэхүү гэрээнд болон зээлийн эргэн төлөлтийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах, зээлдэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхгүй байх, чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

7.3. Зээлдэгч нь зээлийн төлбөрийг /Хавсралт1-д/ дурдсан хугацаанд эргэн төлөх үүргэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлийн үнийн дүнгээс 20 хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлнө.

Найм. Бусад зүйл

8.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална. Эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.2. Талууд шаардлагатай гэж үзвэл энэ гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

8.3. Гэрээнд зааснаас бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг баримтлан зохицуулна.

8.4. Энэхүү гэрээний заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн зөвшилцөлд эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.5. Талууд хэрэг маргаанаа шийдвэрлэх шүүхийн харьяаллыг зээлдүүлэгч буюу Сангийн нутаг дэвсгэрийн шүүх гэж тохиролцов.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Зээлдүүлэгчийг төлөөлж:
Боловсролын зээлийн сангийн
захирал:
/ /

Зээлдэгчийг төлөөлж:
.....
оюутан, суралцагч

Утас:
Боловсролын зээлийн сангийн
Зээлийн албаны дарга
/ /

Утас:
Итгэмжлэгдсэн төлөөлөгч:
/ /
Ургийн овог:
Эцэг/эх/-ийн нэр:

Регистрийн дугаар:

Утас:

Өөрийн нэр:

/ /